



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтай дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/248

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА

1 АУДИТЫН ТАЙЛАН

1.1 Оршил

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга О.Алтансүх-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.02.07-наас 2017.02.10-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.02.10-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт ахлах аудитор Д.Цэрэндорж аудитор Ш.Гүрпүрэв, Ш.Оюунтөгс хариуцаж хэрэгжүүлэв.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.01.26-нд төрийн аудитын байгууллагад 2017.01.26-ны өдрийн 01/39-р албан бичгээр ирүүлсэн байна.

1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар эрхэм зорилгын дор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам-ийн эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангахад оршино.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхэлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Гэр бүлийн хөгжил, тогтвортой байдлыг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах хүүхдийн эрх хөгжил, хамгааллын үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг хангах, залуучуудын хөгжил нийгмийн оролцоог дэмжихэд оршино

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан

төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яамнаас батлагдсан бодлогын баримт бичиг байна.

Аудитын явцад тус байгууллагын дотоод хяналтын албатай уулзалт хийж аудит хийсэн тайлан, орон нутгийн хүүхэд харах үйлчилгээний хөрөнгийн зарцуулалтанд хангалттай хяналт тавьж ажилласан байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд хангаттай байна гэж үзлээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн "Acolous" програм хангамж ашиглажээ.

1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн

үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч тогилуулья.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 3 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 9 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 3 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих 3 шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайланг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн -ийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосонтой холбоотой юм.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,470.7 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 109.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон.

1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 6 чиглэлээр 11 эрсдэлтэй асуудалд 11 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 60 хувь буюу 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	4	55.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	4	55.0	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

1.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2016 онд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсвөөс орон нутгийн хүүхэд харах үйлчилгээнд нийт 3,799.3 сая төгрөгөөр санхүүжүүлсэн бөгөөд зарцуулалтанд хяналт тавих.

1.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 5,635.9 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	5,635.9	5,168.0	8.3%	4.7
1.1	Урсгал зардал	5,635.9	5,168.0	8.3%	4.7

Төсөвт зардлын гүйцэтгэл 91.7 хувь байгаа нь холбоотой байна.

1.12 Шилэн дансны мэдээлэл

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 11 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 11 горим сорил хэрэгжүүлэв.

1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 76 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 01/39 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаар мэдээллийг дахин нягталсан болно.

1.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31 ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил

гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

Асуудал 1: Зардлын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

2016 онд хүүхэд харах үйлчилгээний үйл ажиллагаанд хяналт тавихад зориулж аймаг бүрт 2.0 сая нийт 40.0 сая төгрөг зарцуулсан байна. Хяналтын зардлын тайланг хүлээж авсан байдалтай танилцахад 3 аймаг 4.3 сая төгрөгийн зардлыг дутуу тайлагнасан, мөн 3 аймаг хяналтын зардлын 6.0 сая төгрөгийн тайланг ирүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд

Засгийн газрын тогтоол шийдвэрүүд хэрэгжихгүй байх, хөрөнгө мөнгө үрэгдэх

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

Асуудал 2: Зардлын талаар

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2

ҮАГ-ын ажиглалт

2016 оны сүүлийн хагас жилд гадны байгууллага, хүмүүсээр хийж гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг шалгахад анхан шатны баримтын бүрдэл дутуу 22.3 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэн тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Анхан шатны баримтын бүрдэл хангахгүй байх, хөрөнгө, мөнгө үрэгдэх,

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль мөрдөж, хөтөлбөр, арга хэмжээ харицсан ажилтнууд анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

Асуудал 3: Тэтгэмж, урамшуулалын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/58 дугаар тушаалаар бүтцийн өөрчлөлтөөр ажлаас халагдсан 23 хүнд тэтгэмж олгохдоо албан тушаалын цалингаас тооцоогүй нэмэгдэл орсон дүнгээс бодож 3.4 сая төгрөгийг эрх зүйн үндэслэлгүй олгосон, газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/42 дугаар тушаалаар 2016 оны үйл ажиллагааны үр дүнгийн урамшууллыг олгохдоо шинээр ажилд орсон, ажилласан хугацаа, ажлын үр дүнг харгалзахгүйгээр бүх ажилтанд хавтгайруулж шагнасны дотор шинээр ажилд орсон 23 хүнд 5.4 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.4-т "төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах, эсхүл 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлэг тухайн байгууллагаас олгоно", Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид шагнал урамшуулал олгох журам"-ын 5-д "Төрийн байгууллагын захиргаа нь мэргэжлийн өндөр үр чадвар, идэвх, санаачилга гарган, албан үүргээ тогтмол чанартай сайн биелүүлж, ажлын өндөр амжилт гаргасан, албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэж, мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлж байгаа төрийн албан хаагчид улирлын ажлын нь үр дүнгээр албан тушаалын сарын цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгож болно" гэсэн заалттай зөрчилдөж байна.

Эрсдэлүүд

Цалин, тэтгэмж илүү олгох, хөрөнгө мөнгө үргүй зарцуулах

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн албаны тухай хууль болон Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт Төрийн албан хаагчид шагнал урамшуулал олгох журмыг мөрдөж ажиллах

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

Асуудал 4: Шатахууны талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд 13.6 сая төгрөгийн тээвэр шатахууны зардал гарсан боловч жолоочийн тооцооны хуудас дутуу, тооцоог бодож баталгаажуулаагүй, Засгийн газрын 349 дугаар тогтоолоор батлагдсан норм нормативыг мөрдөж ажиллаагүй, хувийн автомашинд шатахуун зарцуулсан, жолоочийн тооцооны хуудсыг баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийг үр ашиггүй зарцуулах, хөрөнгө мөнгө үрэгдэх

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 349 дугаар тогтоолоор батлагдсан норм нормативыг мөрдөж ажиллах, жолооч нарын тооцооны хуудас НХМаягт-4-ийг бүрэн хөтлөж, хэвшүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

Асуудал 5: Орон тооны талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 8 дугаар сарын 26-ний өдрийн Б/42 дугаар тушаалаар "Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг батласан байна. Сайдын тушаалаар тус газрын удирдлагын орон тоог дарга-1, дэд дарга-1 байхаар тогтоосон нь Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 3 дах заалт "бүх шатны Засаг даргын орлогч, төсөвт байгууллагын дэд дарга, яам, агентлагын газрын орлогч дарга, даргын туслах, төсвөөс цалинждаг зөвлөх зэрэг орон тоог цөөлөх, цомхотгох" гэсэн заалттай нийцэхгүй байна;

Эрсдэлүүд

Засгийн газрын тогтоол шийдвэрүүд хэрэгжихгүй байх, орон тоо, зардал хэтрэх,

ҮАГ-ын зөвлөмж

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,617,798.08	14,737,632.18
	МӨНГӨН ХӨРӨНГӨ	800.00	258,000.00
	Кассанд байгаа бэлэн мөнгө	800.00	258,000.00
40	Касс арилжааны банк	800.00	258,000.00
	АВЛАГА	9,250,824.08	-
300	Татаас, санхүүжилтийн авлага	9,250,824.08	-
	БАРАА МАТЕРИАЛ	31,366,174.00	14,479,632.18
4	Хангамжийн материал	31,366,174.00	14,479,632.18
410	Бичиг хэргийн материал	2,231,400.00	699,110.00
420	Аж ахуйн материал	511,700.00	511,700.00
470	Бусад хангамжийн материал	28,623,074.00	13,268,822.18
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,226,254,189.51	1,111,503,649.06
	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,226,254,189.51	1,111,503,649.06
01	Газар		
02	Биег хөрөнгө	1,226,254,189.51	1,111,503,649.06
0201	Барилга, байгууламж, орон сууц	1,916,728,300.00	1,916,728,300.00
0202	Хуримтлагдсан элэгдэл	(1,047,318,758.28)	(1,079,264,229.96)
0203	Авто-тээврийн хэрэгсэл	340,633,000.00	447,677,209.50
0204	Хуримтлагдсан элэгдэл	(150,916,888.76)	(306,907,520.72)
0205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	123,351,900.00	117,316,496.00
0206	Хуримтлагдсан элэгдэл	(66,493,013.43)	(81,185,671.59)
0207	Тавилга, аж ахуйн эд хогшил	99,143,078.00	106,718,728.00
0208	Хуримтлагдсан элэгдэл	(41,501,941.02)	(55,318,447.97)
0209	Зам, гүүрийн байгууламж	5,850,000.00	5,850,000.00
0210	Хуримтлагдсан элэгдэл	(5,850,000.00)	(5,850,000.00)
0214	Бусад үндсэн хөрөнгө	109,475,222.00	109,475,222.00
0215	Хуримтлагдсан элэгдэл	(56,846,709.00)	(63,736,436.20)
03	Биег бус хөрөнгө	-	-
0301	Програм хангамж	1,135,000.00	1,135,000.00
0302	Хуримтлагдсан элэгдэл	(1,135,000.00)	(1,135,000.00)
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-IV-Н	1,266,871,987.59	1,126,241,281.24
	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,770,125.00	722,800.00
	БОГИНО ХУГААЦААТ ӨР ТӨЛБӨР	1,770,125.00	722,800.00
113	Өглөг	1,770,125.00	722,800.00
11310	Ажилчидтай холбогдсон өглөг	700,125.00	722,800.00
1136	Бусад өглөг	1,070,000.00	-
11361	Байгууллагад төлөх өглөг	1,070,000.00	-
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,265,101,862.59	1,125,518,481.24
	Засгийн газрын хувь оролцоо	1,265,101,862.59	1,125,518,481.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	511,123,914.11	511,123,914.11
51101	Өмч - төрийн	511,123,914.11	511,123,914.11
512	Хуримтлагдсан үр дүн	206,715,360.72	67,131,979.37
51210	Өмнөх үеийн үр дүн	206,715,360.72	206,715,360.72
51220	Тайланг үеийн үр дүн		(139,583,381.35)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		547,262,587.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	547,262,587.76	547,262,587.76
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV-V	1,266,871,987.59	1,126,241,281.24

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Сайт	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (П)	1,835,740,080.82	5,333,288,599.4
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		26,884,374.4
	Нийтлэг татварын бус орлого	-	26,884,374.4
004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	26,884,374.4
0045	Үнэ төлбөргүй хүдээн авсан орлого	-	26,884,374.4
	Хөрөнгийн орлого		
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,835,740,080.82	5,306,404,225.0
0	Удсын төвлөрсөн төсвөөс	1,567,619,852.18	5,168,014,600.00
001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,567,619,852.18	5,168,014,600.00
1	Нэмэлт санхүүжилтийн орлого	268,120,228.64	138,389,625.00
101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	261,342,249.86	138,389,625.00
106	Төсвийн урамшуулал	6,777,978.78	-
20	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,926,184,812.58	5,470,713,315.40
	УРСГАЛ ЗАРДАЛ	1,926,184,812.58	5,470,713,315.40
0	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,893,798,574.38	5,144,171,793.32
01	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	504,817,553.00	465,123,500.00
0101	Үндсэн цалин	433,608,153.00	394,641,200.00
0102	Нэмэгдэл		
0103	Унаа хоолны хөнгөлөлт	31,218,000.00	31,218,000.00
0104	Урамшуулал		
0105	Гэрээт ажлын хөлс	39,991,400.00	39,264,300.00
0106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
02	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,258,035.00	49,411,775.00
0201	Тэтгэврийн даатгал	31,346,022.00	31,443,857.00
0202	Тэтгэмжийн даатгал	3,582,403.00	3,593,583.00
0203	ҮОМШӨ-ний даатгал	4,478,003.00	4,491,980.00
0204	Ажигчидлийн даатгал	895,601.00	898,396.00
0205	Эрүүл мэндийн даатгал	8,956,006.00	8,983,959.00
0206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,344,979.18	46,036,723.00
10301	Гэрэл, цахилгаан	21,168,160.00	14,370,325.00
10302	Түлш, халаалт	20,959,241.00	22,713,757.00
10303	Цэвэр, бохир ус	2,157,578.18	2,012,641.00
10304	Байрны түрээс	8,060,000.00	6,940,000.00
10305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
104	Хангамж, бараа материалын зардал	77,868,050.86	66,942,433.50
10401	Бичиг хэрэг	7,075,700.00	13,938,790.00
10402	Тээвэр, шатахуун	33,372,612.86	13,628,420.00
10403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,796,718.00	5,487,614.00
10404	Ном, хэвлэл	30,705,900.00	8,097,900.00

10405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
10406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	917,120.00	25,789,709.5
10407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
105	Нормативт зардал	45,334,009.00	40,205,000.0
10501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
10502	Хоол, хүнс	43,584,009.00	40,205,000.0
10503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,750,000.00	
106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,159,560.00	39,752,600.0
10601	Багаж, техник, хэрэгсэл		
10602	Тавилга		
10603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
10604	Урсгал засвар	7,159,560.00	39,752,600.0
107	Томилолт, зочны зардал	34,989,600.00	19,809,000.0
10701	Гадаад албан томилолт	990,000.00	
10702	Дотоод албан томилолт	33,999,600.00	19,381,500.0
10703	Зочин төлөөлөгч хүдээн авах		427,500.0
108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	190,602,768.00	3,996,400,882.0
10801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	184,493,890.00	3,990,277,510.0
10802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
10803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	994,760.0
10804	Тээврийн хэрэгслийн татвар	512,400.00	488,900.0
10805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	870,000.00	932,000.0
10806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,598,966.00	3,639,600.0
10807	Газрын төлбөр	68,112.00	68,112.0
109	Бараа үйлчилгээний бусад зардал	931,424,019.34	420,489,879.8
10901	Бараа үйлчилгээний бусад зардал	753,949,682.00	259,273,695.0
10902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	56,486,324.00	27,125,336.0
10903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	120,988,013.34	134,090,848.8
10904	Нөйдөөргүй авлагын алдагдал		
11	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,386,238.20	326,541,522.0
111	Засгийн газрын урсгал шилжүүлэг	16,374,038.20	-
11101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	16,374,038.20	
11102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
112	Бусад урсгал шилжүүлэг	16,012,200.00	120,528,908.0
11204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,343,300.00	97,513,900.0
11207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,068,900.00	16,238,008.0
11208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласныг албан		
11209	Уаажилдал төлөөс, эмнэлгээс тэтгэмж		
11209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	6,777,000.00
113	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	206,012,614.08
11303	Төвлөрүүлэх шилжүүлэг		206,012,614.08
11304	Хөрөнгийн		
123	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(90,444,731.76)	(137,424,715.99)
124	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,158,665.36
12401	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		2,158,665.36
125	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(2,158,665.36)
	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(90,444,731.76)	(139,583,381.35)

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Нснм код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,817,219,098.32	5,315,655,049.08
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,817,219,098.32	5,315,655,049.08
	Улсын төвлөрсөн төсвөөс	1,567,619,852.18	5,177,265,424.08
001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,567,619,852.18	5,168,014,600.00
002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
003	Төвлөрүүлэх шилжүүлэг		9,250,824.08
11	Нэмэлт санхүүжилтийн орлого	249,599,246.14	138,389,625.00
101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээ авсан хандив, тусламж	205,735,193.86	138,389,625.00
105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,086,073.50	
1106	Төсвийн урамшуулал	6,777,978.78	
	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,817,218,298.32	5,315,397,849.08
	УРСГАЛ ЗАРДАЛ	1,817,218,298.32	5,315,397,849.08
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,775,581,236.04	4,988,856,327.00
01	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	504,926,033.00	464,658,700.00
0101	Үндсэн цалин	433,716,633.00	394,176,400.00
0102	Нэмэгдэл		
0103	Унаа хоолны хөнгөлөлт	31,218,000.00	31,218,000.00
0104	Урамшуулал		
0105	Гэрээт ажлын хөлс	39,991,400.00	39,264,300.00
0106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,450,230.00	50,111,100.00
10201	Тэтгэврийн даатгал	30,831,965.00	31,888,882.00
10202	Тэтгэмжийн даатгал	3,523,653.00	3,644,443.00
10203	ҮОМШӨ-ний даатгал	4,404,566.00	4,555,555.00
10204	Ажилгүйдлийн даатгал	880,913.00	911,111.00
10205	Эрүүд мэндийн даатгал	8,809,133.00	9,111,109.00
10206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,344,979.18	46,836,723.00
10301	Гэрэл, цахилгаан	21,168,160.00	14,370,325.00
10302	Түлш, халаалт	20,959,241.00	22,713,757.00
10303	Цэвэр, бохир ус	2,157,578.18	2,012,641.00
10304	Байрны түрээс	8,060,000.00	7,740,000.00
10305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
104	Хангамж, бараа материалын зардал	77,868,050.86	40,174,691.00
10401	Бичиг хэрэг	7,075,700.00	10,166,200.00
10402	Тээвэр, шатахуун	33,372,612.86	13,628,420.00
10403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,796,718.00	5,487,614.00
10404	Ном, хэвлэл	30,705,900.00	8,097,900.00
10405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	917,120.00	2,794,557.00
10406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	45,334,009.00	40,205,000.00
105	Нормативт зардал		
10501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,584,009.00	40,205,000.00
10502	Хоол, хүнс	1,750,000.00	
10503	Нормын хувцас, зөөлөн элдлэл	7,159,560.00	39,753,400.00
106	Эд хогшил, урсгал засварын зардал		

ЦЭВЭР ХӨРӨНГӨӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	511,123,914.11	547,262,587.76	297,160,092.48		1,355,546,594.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	511,123,914.11	547,262,587.76	297,160,092.48	0.00	1,355,546,594.35
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланда хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайланг үеийн үр дүн			-90,444,731.76		-90,444,731.76
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	511,123,914.11	547,262,587.76	206,715,360.72	0.00	1,265,101,862.59
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	511,123,914.11	547,262,587.76	206,715,360.72	0.00	1,265,101,862.59
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	511,123,914.11	547,262,587.76	206,715,360.72	0.00	1,265,101,862.59
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланда хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайланг үеийн үр дүн			-139,583,381.35		-139,583,381.35
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	511,123,914.11	547,262,587.76	67,131,979.37	0.00	1,125,518,481.24

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТТ

Узүүлэлт	Өмнөх оныг		/ төгрөгөөр /	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайланг оныг	
			Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Монго, түүнтэй ажилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДУН	1,721,846,500.00	1,567,619,852.18	5,635,884,100.00	5,168,014,600.00
УРСГАЛ ЗАРДАЛ	1,721,846,500.00	1,567,619,852.18	5,635,884,100.00	5,168,014,600.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,712,177,600.00	1,551,607,652.18	5,522,131,800.00	4,848,269,857.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	451,146,100.00	439,936,533.00	434,210,700.00	434,210,700.00
0101 Үндсэн цалин	376,301,100.00	368,727,133.00	363,728,400.00	363,728,400.00
0102 Нэмэгдэл				
0103 Уйна хоолны хөнгөлөлт	31,218,000.00	31,218,000.00	31,218,000.00	31,218,000.00
0104 Урамшуулал				
0105 Гэрээт ажлын хөлс	43,627,000.00	39,991,400.00	39,264,300.00	39,264,300.00
0201 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,626,200.00	48,450,230.00	50,111,100.00	50,111,100.00
0201 Тэтгэврийн даатгал	31,580,300.00	30,831,965.00	31,888,882.00	31,888,882.00
0202 Тэтгэмжийн даатгал	3,609,200.00	3,523,653.00	3,644,443.00	3,644,443.00
0203 ҮОМШӨ-ний даатгал	4,511,500.00	4,404,566.00	4,555,555.00	4,555,555.00
0204 Ажилгүйдлийн даатгал	902,300.00	880,913.00	911,111.00	911,111.00
0205 Эрүүл мэндийн даатгал	9,022,900.00	8,809,133.00	9,111,109.00	9,111,109.00
0301 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,136,600.00	44,284,979.18	39,506,500.00	39,096,723.00
0301 Гэрэл, цахилгаан	20,328,000.00	21,168,160.00	14,477,200.00	14,370,325.00
0302 Түлш, халаалт	28,856,800.00	20,959,241.00	22,892,100.00	22,713,757.00
0303 Цэжэр, бохир ус	2,951,800.00	2,157,578.18	2,137,200.00	2,012,641.00
0304 Байрны түрээс				
0401 Хангамж, бараа материалын зардал	17,570,300.00	12,415,628.00	15,136,400.00	15,091,521.00
0401 Бичиг хэрэг	7,235,100.00	2,649,200.00	5,804,500.00	5,139,650.00
0402 Тээвэр, шатахуун	5,562,300.00	3,560,000.00	4,379,200.00	1,655,000.00
0403 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,599,400.00	4,893,408.00	3,459,600.00	5,057,614.00
0404 Нөм, хэмлэл	173,500.00	395,900.00		444,700.00
0405 Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, амьтгал		917,120.00	1,493,100.00	2,794,557.00
0406 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс				
0407 Аж ахуйн материал худалдан авах зардал	1,756,600.00	1,750,000.00		
0501 Нормативт зардал				
0501 Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл				
0502 Хөөд, хүнс	1,756,600.00	1,750,000.00		
0503 Нормын хувцас, зөвлөн эдлэл	4,320,000.00	7,159,560.00	40,754,200.00	39,752,600.00
0601 Эд хогшил, урсгал засварын зардал	4,320,000.00	7,159,560.00	40,754,200.00	39,752,600.00
0601 Урсгал засвар	3,968,500.00	2,150,000.00	148,500.00	148,500.00
0701 Томилгоо, зочин зардал	1,882,900.00	990,000.00		
0701 Гдайд албан томилгоо	332,700.00	1,160,000.00	148,500.00	148,500.00
0702 Дотоод албан томилгоо	1,752,900.00			
0703 Зочин таллоолч хүтээн авах				
0801 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хурх	201,600,000.00	186,438,202.00	4,650,462,300.00	3,979,703,882.00
0801 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	194,970,400.00	180,971,890.00	4,641,032,700.00	3,971,580,510.00
0801 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	59,400.00	1,000,000.00	994,760.00
0801 Даяаталын үйлчилгээ	790,000.00	512,400.00	790,000.00	922,000.00
0801 Төврийн хэрэгслийн татвар	1,000,000.00	870,000.00	1,000,000.00	3,639,600.00
0801 Төврийн хэрэгслийн өношлогоо	3,639,600.00	3,956,400.00	3,639,600.00	68,112.00
0801 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	68,112.00	200,000.00	
0801 Газрын төлбөр				
0801 Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж				
0801 Улсын мэдээллийн мөнгөт хэвлэх, бэлтгэх	930,053,300.00	809,022,510.00	291,802,100.00	290,154,831.00
0901 Бараа үйлчилгээний бусад зардал	856,053,300.00	756,249,682.00	265,686,700.00	264,039,495.00
0901 Бараа үйлчилгээний бусад зардал	74,000,000.00	52,772,838.00	26,115,400.00	26,115,336.00
0901 Хөгжөл үйлдвэрлэлийн дэдлага хийх	9,668,900.00	16,012,200.00	113,752,300.00	119,744,743.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				205,992,835.00
0901 Засгийн газрын урсгал шилжүүлэг				113,751,908.00
0901 Засгийн газрын дотоод шилжүүлэг				
0901 Төвлөрүүлэх шилжүүлэг	9,668,900.00	16,012,200.00	113,752,300.00	
0901 Бусад урсгал шилжүүлэг				

1202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж				
1203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж				
1204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		7,343,300.00	97,513,900.00	97,513,900.00
1205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал				
1206	Ээлжийн амралтаар нутаг явах уналмы хөнгөлөлт				
1207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,068,900.00	7,068,900.00	16,238,400.00	16,238,008.00
1208	Халдаг орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг				
1209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,600,000.00	1,600,000.00		
1210	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,721,846,500.00	1,567,619,852.18	5,635,884,100.00	5,168,014,600.00
1210	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,721,846,500.00	1,567,619,852.18	5,635,884,100.00	5,168,014,600.00
12101	Улсын төсвөөс санхүүжих	1,721,846,500.00	1,567,619,852.18	5,635,884,100.00	5,168,014,600.00